ЭМЧИЙН ЗӨВЛӨЛГӨӨ

# Эрүүл энхийн өдөрт

*1969 оны 10 дугаар сарын 25*

СУРВАЛЖЛАГА

## Хүүхдийг уушигны хатгалгаа өвчнөөс урьдчилан сэргийлье

Уушигны хатгалгаа өвчин нь бага насны хүүхдийн өвчлөлийн дотроос олонтой тохиолддог өвчний нэг юм. Хатгалгаа өвчин нь даарч хөрөх, халуун байрнаас гэнэт гарах, бие сулрах, ханиад хүрээд удах зэрэг шалтгаанаас тусахын хамт хүүхдийн арчилгаа маллагаа муу тохиромжгүйгээс болж амархан тусах тал байдаг.

Өвчилсөн хүүхэд нь тайван биш болж уцаарлах, нойр хоолонд муудах, арьс нь цайх, хамар уруулын нугалаа нь эргэн тойрондоо хөхрөх, хамар нь сарталзах, орчиндоо сонирхолгүй болох шинжүүд үзэгдэнэ.

Мөн хүүхэд амьсгаадаж судасны лугшилт нь олшрох шинж мэдэгдэнэ.

Зарим бага насны хүүхдэд дээрх шинж тэмдэг тодорхойгүй тусч болно.

Өвчилсөн хүүхдийг эмчид үзүүлэн зохих эмчилгээнүүдийг хийлгэхгүй бол хүндэрч архагшах, тэрч байтугай үхэлд хүргэх аюултай байдаг.

Иймээс хүүхдээ үргэлж анхаарч, энэ өвчнөөс урьдчилан сэргийлж, зөвлөлгөө авч байх хэрэгтэй.

Ер нь хүүхдийн хоол ундыг нь тохируулж халуун хүйтэн нь нэгэн жигд, цэвэр агаартай орчинд байлгах нь сайн.

Хэтэрхий халуун байранд бэгнэх нь хүүхдийн биенийг өвчин тусахад хялбархан болгодог.

Хүүхдээ чийрэгжүүлэхийн тулд хоол ундыг нь цагтай, нарийн дэглэмтэй өгч, цэвэр агаарт үргэлж гарган, бүлээн усанд тогтмол оруулж байх нь нэн ашигтай.

**Хүний их эмч Н. Дашням**

*Их ойнуудын өмнө*

## ЭМИЙН САНГИЙНХНЫ АМЖИЛТ

Аймгийн эмийн сангийн хамт олон (дарга нь Осор) В. И. Ленинийн мэндэлсний 100 жилийн ой, Ардын хувьсгалын 50 жилийн ойг угтаж 1969 оны эхний 9 сарын аймгийн хэмжээний эм борлуулах, татах, жор хүлээн авах төлөвлөгөөг 100—120,5 хувиар биелүүлсний дотор Жаргалант, Баянчандмань, Их хайрхан сум, САА, хороо захиргааны эмийн сангийнхан 127-142 хувиар биелүүлж сайхан амжилт гаргав.

Тэрчлэн сум—нэгдэл, сангийн аж ахуйн төв, бригад, тасаг, айл өрхөөр эм худалдах, малчид, тариачид, хадланчдад зориулсан эмийн санг бэлтгэн худалдаалах, эм бараагаар өргөн сурталчлах, барилга засварлах, эд аж ахуйгаа сэлбэн засах, будах эмнэлэг эмийн сангаа сурталчилсан булан байгуулж, түүндээ эмнэлэг гэгээрлийн суртал нэвтрүүлгийг өргөн зохиох ажлыг хийж байна.

Аймгийн эмийн сангийн мэргэжилтэн Буд «Ус нэрэх аппарат» санаачилж ажилдаа нэвтрүүлсэн нь хөдөлмөрийг хөнгөвчлөж, шингэн бэлтгэлүүдийг бэлтгэх хугацааг богиносгож, үйлчилгээг хөнгөн шуурхай болгоход зохих үр нөлөөгөө өгчээ.

Мөн Зүмхүү ахлагчтай СХБ—ынхан хамт олноороо үйлчилгээнд соёлч боловсон байдлыг нэвтрүүлэх нилээд ажлыг санаачлан хийж байна.

Тухайлбал үйлчлүүлэгчдэд зориулан «эм уух ширээ», «эмийн сан» зэргийг санаачлан хийжээ.

Аймгийн эмийн санчдын дотор олон түмэнд хөнгөн шуурхай үйлчилдэг, ажил төрлөөрөө шалгарсан тэргүүний сайчууд олон бий.

Жаргалант сум—САА-н дундын больницын эмийн сангийн эрхлэгч Намсрайжав, Батсүмбэр, Баянчандмань сум САА, хороо захиргааны эмийн санч Намсрай, Содном, аймгийн эмийн сангийн жор хүлээн авагч Хаян, Ичинхорлоо, Зүмхүү, нягтлан бодогч Нямхүү нарын олон сайчуудыг дурьдаж болно.

Аймгийн эмийн сангийн хамт олон их ойнуудыг угтаж 1969 оны эм борлуулах, жор хүлээн авах төлөвлөгөөг хугацааны нь өмнө биелүүлэх, үйлчилгээнд соёлч боловсон байдлыг үлгэр жишээчээр нэвтрүүлэхээр мэрийн ажиллаж байна.

**Н. Нанжид**

## *Олны талархал хүлээсэн эх*

Өнөөдөр Тогтох эмч, хайртай хүүхэддээ захидал бичээд огтхонч завгүй сууна.

Тэр захидалдаа:

. . . Охиныхоо өсөлт торинолт, өдөр тутмын ажиллагаанд та үргэлж анхаараарай.

Юуны өмнө та охиноо хөхнөөс нь битгий гаргаарай. Хөхөө гурван цагийн зайтай тогтмол хөхүүлж байгаарай.

Хүүхдэд чинь цэвэр агаар юу юунаас илүү хэрэгтэй шүү! . . . гээд ган үзэгний нь хушуугаар үсэг өрөгдөн үг зурайна.

Эх баригч Тогтох 1965 онд Анагаах ухааны соёлч дунд сургуулийг амжилттай төгсчээ.

Тэрээр сүүлийн гурван жилд аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт эх баригчийн ажлыг хийхдээ өөрийн мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлж, амаржихаар ирсэн эхчүүдэд зөвлөлгөө санамж өгөх, эх барихын анхны тусламжийг чадамгай эзэмшиж ялангуяа цус алдах, эхэс түдэх, эхсийг гардан авах зэрэг эх барихын нарийн тусламжийг зөв үзүүлдэгээрээ олон эхчүүдийн амийг аварч, тэдний хайр талархлыг зүй ёсоор хүлээж байгаа манай тэргүүний эх баригчийн нэг нь юм.

Тогтох, амаржаад гарсан эхчүүдэд өөрийгөө ба үр хүүхдээ хэрхэн яаж арчлан сувилах тухай зөвлөлгөө санамж өгдөг ба зарим эхчүүдэд захидал бичих журмаар эмчийн энэрэнгүй сэтгэлийн үүднээс үр хүүхдээ зөв бойжуулах, арчлан сувилахад нь зөвлөдөг.

Энэ удаа ч гэсэн Тогтох эх баригч өөрийн эх барьж авсан 297 дахь хүүхдийн эх Дэнсмаад зөвлөлгөө өгөх журмаар захидал бичиж суугаа нь энэ билээ.

МХЗЭ—ийн гишүүн, эх баригч бага эмч Тогтохыг Зуунмод хотын яслийн насны хүүхдийн нилээд хэсэг нь эхээ гэж хүндэт гэдэг болжээ.

Энэ хүн, эх үрсийн эрүүл мэндийн төлөө цаг мөчтэй уралдан хүчин зүтгэж явна.

**Ж. Доржготов**

## Туршлагатай лаборант

«Лаборонт хүн олон түмэнд хөнгөн шуурхай, гомдоохгүй үйлчилж, тэдэнд өвчин эмгэгээ эмчлүүлэхэд нь зохих хувь нэмрээ үзүүлэхийг хичээн зүтгэдэг билээ» гэж ярьж суугаа ажил амьдралын баялаг туршлагатай энэ хүнийг Чойжилын Дашзэвэг гэдэг.

Дашзэвэг гуай 1949 оноос эхлээд өнөө болтол 20 гаруй жил лаборантын ажил хийхдээ үйлчлүүлэгч олон түмэндээ хөнгөн шуурхай үйлчилж олон зуун мянган хүний өвчний онош тогтооход, лабораторийн шинжилгээгээр, тодруулан өгсөн хүн юм.

Тэрээр зөвхөн сүүлийн 5 жилд клиник лабораторийн шинжилгээг 13133 хүнд хийснийг өдөр тутмын ажлын нэгжээр үзвэл 64860 нэгж ажилд хүрч байна.

Дашзэвэг гуай клиник лабораторийн шинжилгээг зөвхөн амбулаториор ирсэн хүнд хийгээд сууж байдаг хүн бишээ.

Тэрээр хөдөө орон нутагт очиж шинжилгээ хийдэг байна.

Зөвхөн сүүлийн гурван жилд нүүдлийн амбулаториор хөдөө орон нутагт явахдаа хагас мянга шахам хүнд үйлчилжээ.

Ажилсаг хичээнгүй чанар, идэвх зүтгэлээрээ хамт олноо хошуучлагч Дашзэвэг гуай аймгийн төвийн нэгдсэн больницын лаборантаар ажиллаж байна.

**Манай идэвхтэн**

## *Хүүхдийг зөв боловсон хүмүүжүүлж байна*

Аймгийн төвийн хүүхэд саатуулах газрын хамт олон ясли, цэцэрлэгийн улсын зөвлөлгөөний шийдвэр, Ж. Самбуу даргын нэрэмжит болзлыг биелүүлэхээр ажилчин бүрийн хооронд социалист уралдааныг өрнүүлж, ажлын хариуцлага, сахилга батыг өндөржүүлэн тэдний ажлыг нь 1000 баллын системээр дүгнэн, ажилчид, эцэг эхийн зөвлөлгөөнийг тогтмолжуулан ажилласнаар 1969 оны 3 дугаар улирлын ор хоног, урьдчилан сэргийлэх тарилгын төлөвлөгөөг 100-100,9 хувиар гүйцэтгэж, тэргүүний ясли болохоор авсан үүргээ биелүүлж байна. Хүүхдэд юмны өнгө, дүрс, хэлбэрийг зөв таних, хэлүүлэх, орчинтойгоо зөв харьцах, соёлч боловсон хувцаслаж, хоollож сургах ажлыг эрэмбэ дараалалтай зохиож байна.

Хүмүүжүүлэгч Дашзэвэг, Цэвэлмаа, Гомбосүрэн нарын анги 40 гаруй үзүүлэн санаачлан хийсний дотор таван хушуу малын дүрс, төрөл бүрийн даавууны өөдөс, ногоогоор хийсэн тоглоом нь хүүхдийн хүмүүжилд үр нөлөө өгөхүйц цэвэр үзэмжтэй болжээ.

**Н. Нацагюм**

## Урт наслахын тулд

Хүний эрүүл энх, урт наслахтай холбогдон гарч байгаа орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилтуудыг амьдралдаа хэрэгжүүлэх нь чухал юм.

Оросын алдарт эрдэмтэн И. И. Мечников өтлөх ба урт наслахын тухай асуудлыг судалж байхдаа Ортобиозын тухай онолыг боловсруулжээ. Ортобиоз буюу хэвийн амьдралын онол гэдэг нь эрүүл энх урт удаан наслахад зайлшгүй шаардагдах нөхцлүүдийн тухай сургаал юм. Хүн, урт удаан наслахын тулд ажиллах, хөдөлмөрлөх, амрахдаа цагийн нарийн хуваарийг баримтлах, өглөө ба өдрийн гимнастикийг тогтмол хийж биеийн тамирын дасгалуудаар байнга хичээллэх.

Ядарсан мэдрэлийн системийг сэргээж хоногт 7—8 цаг нойрсож амарч байхын дээр биедээ тохиолдсон өвчнийг цаг тухайд нь сайн эмчлүүлж бүрэн эдгэрүүлэх нь чухал. Мөн урт наслалтыг богиносгож биед хортойгоор нөлөөлдөг архи тамхи хэрэглэхийг цээрлэн, төрөл бүрийн витаминуудаар баялаг хоол тэжээлийг цагийн нарийн хуваарьтай хэрэглэж заншивал зохино.

Эдгээрийг амьдрал ахуйдаа хэвшүүлж чадвал таны эрүүл энх, урт удаан наслахад чухал түлхэц болно.

**Их эмч М. Гүрсэд**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга П. Очирбат

(Х—00753) «Анхдугаар таван жил» сонины үйлдвэрт хэвлэв

Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анхдугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, А. Д. Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

22 дахь жилдээ № 81 (1865) | 1969 оны 10 дугаар сарын 24 | БААСАН

## Цагаан идээний зах

*Манай аймгийн хөдөө аж ахуйн нэгдлүүд БНМАУ-д нэгдэлжих хөдөлгөөн ялсны 10 жилийн ойд зориулж Улаанбаатар хотод цагаан идээний зах гарган, хотын хөдөлмөрчдийг сүү цагаан идээгээр үйлчилж эхэллээ.*

*«Заамар», «Сүхбаатарын зам», «Энхтуул», «Өрнөх-амьдрал», «Монгол-Солонгосын найрамдал» нэгдлүүд айраг 500—4256 литр, сүү 650—2800 литр, тараг 400—1500 литр, үлэмж хэмжээний ааруул, өрөм, ээзгий зэрэг бүтээгдэхүүн бэлтгэн ирж худалдаалж байна.*

*Мөн 11 дүгээр сарын 5-наас эхлэн Зуунмод хотын хөдөлмөрчдийг цагаан идээгээр үйлчлэх аймгийн хөдөө аж ахуйн нэгдлүүдийн цагаан идээний захын ажиллагаа нээгдэх гэж байна.*

**Р. Баярсайхан**

## НЭГДЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ТАЙЛАН СОНГУУЛЬ

Нэгдлүүдийн III их хурлаар батлагдсан нэгдлийн үлгэрчилсэн дүрмэнд Хөдөө Аж Ахуйн нэгдлийн ажлыг эрхлэн удирдах дээд байгууллага нь хөдөө аж ахуйн зөвлөл мөн гэж заасан билээ.

Нэгдлийн үлгэрчилсэн дүрмэнд заасны дагуу нэгдлийн зөвлөлийн гишүүдийг бригадын гишүүдийн хурлаас 10 гишүүн тутмаас 1—3 хүнээр бодож 2 жилийн хугацаагаар санал хураах журмаар илээр сонгож, нэгдлийн зөвлөлийн хурлыг жилд 3-аас доошгүй удаа зарлан хуралдуулж байна.

Нэгдлийн зөвлөлийн тэргүүлэгчид нь олгогдсон эрхийнхээ ёсоор нэгдлийн зөвлөлийг төлөөлөн нэгдлийн бүх ажил хэргийг хариуцан мэдэж захирамжлан гүйцэтгэх, удирдаж зохион байгуулах үүрэгтэй.

Зөвлөлийн тэргүүлэгчид, зөвлөлийн хурлын өмнө ажлаа хариуцаж, түүнд тайлангаа тавьж байх зарчимтай ба нийгмийн аж ахуйг хөгжүүлэх үйл хэрэгт нэгдэлчдийн хүчийг зохион байгуулж оролцуулах явдалд бүх ажлаа чиглүүлнэ.

Нэгдлийн зөвлөл нь нэгдлийн зөвлөлийн хурлаараа нэгдлийн дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах, дотоод журмыг батлах, зөвлөлийн тэргүүлэгчид, хянан байцаах комисс, нэгдлийн дарга, болон хянан байцаах комиссын даргыг нууцаар санал хураах журмаар сонгох, тайлан баланс, хэтийн ба жилийн төлөвлөгөө, хөдөлмөр зохион байгуулалт, ажлын норм, үнэлгээ, хөлсний хэмжээ, аж ахуйн дотоод тооцоог нэвтрүүлэх журам зэрэг нэгдэлч олны амьдралтай холбоотой чухал асуудлуудыг хэлэлцэн батлана.

Үүний зэрэгцээгээр нэгдлийн зөвлөлийн хурал, нэгдлийн үйлдвэрийн салбаруудын үр ашигт ажиллагааг дээшлүүлэхтэй холбогдсон аж ахуйн томоохон арга хэмжээг хэрэгжүүлэх талаар чухал асуудлууд дэвшүүлж, нэгдлийн өмч хөрөнгө, нийгмийн аж ахуйг өндөр ашигтай хөтлөх, хөрөнгө оруулалтыг зөв хийх, мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлэх зэрэг нэгдлийн аж ахуйн ойрын ба хэтийн арга хэмжээг хэлэлцэн шийдвэрлэж байна.

Нэгдлийн зөвлөл, дүрмээр олгогдсон хоёр жилийн эрхийнхээ хугацааг дуусмагц нэгдлийн тайлан сонгуулийн хурлыг хийж зөвлөлийн гишүүд, тэргүүлэгчдээ шинэчлэн сонгоно.

Хөдөө аж ахуйн нэгдлийн зөвлөлүүдийн одоо болох гэж байгаа тайлан сонгуулийн хурал нь БНМАУ—д нэгдэлжих хөдөлгөөн ялсны 10 жилийн ойн өмнөхөн болох гэж байна.

Нэгдлийн зөвлөлийн дотоод ардчиллыг Эрдэнэсант сумын «Саруул-амьдрал», Өнжүүл сумын «Ялалт» зэрэг нэгдлүүд сайн биелүүлж байгаа боловч ихэнх нэгдлүүд нэгдлийн дотоод ардчиллыг хангалтгүй биелүүлж байна.

Хөдөө аж ахуйн нэгдлүүдийн тайлан сонгуулийн хурлыг үзэл суртлын өндөр хэмжээнд явуулахын тулд өөрийн нэгдлийн түүх танилцуулгыг бичиж, нэгдлийн үйлдвэрлэлийн үүсэл хөгжлийг харуулсан булан кабинет байгуулан сурталчлах, хөдөлмөр хамгаалал, тэтгэвэр тэтгэмж, хөдөлмөр зохион байгуулалтыг улам боловсронгуй болгох, нэгдлийн үйлдвэрлэлд төлөвлөлт бүртгэлийн шинэчилсэн системийг тууштай нэвтрүүлэх, мал аж ахуйн өвлийн бэлтгэлийг сайн зохион байгуулж, нийт хөдөлмөрчдийн идэвх санаачлагыг өрнүүлэн дайчилж, 1969 оны төлөвлөгөөт зорилтыг биелүүлсэн амжилтаар угтах нь манай ХАА—н бүх нэгдэл, нийт гишүүдийн эрхэм зорилт болж байна.

## ХОНЬЧИН ОЙДОВ

Баянцагаан сумын 3 дугаар бригадын хоньчин Ойдовын малч ажиллагааны онцлог нь өвлөөс бусад гурван улиралд хонийг өдөр бүр. амьтай усанд усалж, хонь ямааны идээшилж байгаа байдлыг үргэлж ажиглан аль сонирхон идэж байгаа ургамлын элбэг нутгийг дагуулж нутаг хөөж тарга хүч авахуулдагт байна.

Тэрээр ярихдаа:

—Намар хонийг нэг газар 2-оос илүү хэвтүүлэхгүйг хичээдэг.

Мөн өдөр бүр хужирт оруулдаг. Энэ нь тарга сайн авахуулах ба авсан таргыг нь тогтоохоод сайн байдаг.

Хавар таанын шар мод, агь дагуулах ба мал явааргүй сийрэг, хөрс зөөлөнтэй, ногоо амархан цухуйдаг, нөмөр хорго сайтай газар нутаглахыг гол болгодог.

Хонины таргыг гэдэс тогтоох үе, махлуулах үе, өөхлүүлэх үе, арьс зузаатруулах үе гэж би хувьдаа дөрөв хуваадаг.

—Отрыг эргэх дөрвөн улиралд хийх нь ашигтай юм.

Жишээ нь: 1967 оны өвөл би 6 бууц сэлэн нүүсэн. Тэгэхэд мал эцэж турахгүй сайн орсон, гойд сайн юм гэж би ойлгосон.

Ер нь хавар, зун, намар нутаг сэлэх бүрд хонины өнгө зүс огт өөр болж тарга нэмдэг юм.

Олон нүүхийн тулд майхан буюу жижиг гэртэй хөнгөн маягаар явдаг.

Хичнээн ч нүүж байсан амар байдаг юм гэж ярьж байна. Хоньчин Ойдов, энэ малч ажиллагааныхаа үр дүнд 1964 оноос эхлэн 700—850 эр шүдлэн хонь, ямаа маллах хугацаандаа шүдлэн хонь бүрээ 40—44 кг, ямаа бүрээ 30—32 кг-ийн цэвэр жинтэй улсад тушааж иржээ. Одоо их ойнуудыг угтаж 1970 онд шүдлэн хонио 45 кг, ямааг 34 кг-ийн жинтэй тушаах зорилт тавин ажиллаж байна.

**Ч. Хоролсүрэн**

## НЭГДЭЛЖИХ ХӨДӨЛГӨӨН ЯЛСНЫ 10 ЖИЛИЙН ОЙД

Найрамдлын сараар

### Ленин ба кино

Монгол—Зөвлөлтийн найрамдлын сарын ажлыг тохиолдуулан их Лениний мэндэлсний 100 жилийн ойг угтаж Батсүмбэрийн САА—н ажилчны клуб, киноны салбараас „Ленин ба кино" гэдэг зөвлөлтийн киноны 5 хоногийг саяхан зохиолоо.

Энэ үеэр „Лениний 100 жилд", „Ленин ба кино", „Зөвлөлтийн кино урлагийн амжилт" зэрэг фото ба зурагт самбар, булан гаргасны гадна Лениний сэдэвт киноны тайлбарыг дуу хураагчаар дамжуулан хөдөлмөрчдөд өргөн сурталчлав.

Энэ 5 хоногоор „Лениний амьдрал", „Лениний идэр нас", „7 дугаар сарын 6" зэрэг Лениний үйл амьдралыг харуулсан олон сонирхолтой кинонууд гаргаж нийт 2300 гаруй хүнд үйлчилсэн байна.

**Л. Батсүх**
**Д. Долгормаа**

### 1970 оны ажилд

Батсүмбэрийн САА—н худалдаа бэлтгэлийн ангийн харъяа Хишигт даргатай талхны салбар жилийн төлөвлөгөөг 94 хоногийн өмнө 108,6 хувийн амжилттай биелүүлж 1970 оныхоо ажилд оров.

Талхчин Долгор, Долгорсүрэн, Ханд, Өнөр нар төлөвлөгөөгөө 100,3-104,7 хувиар биелүүлсэн байна.

**Өвөлжөө рүү...**

Батсүмбэрийн САА—н дунд сургуулийн багш сурагчид САА—н малын бригадад өвс татах 3 хоногийн цуваа гаргаж ажиллав. Анхны өдрийн байдлаар 4250 бухал татан 1 нуруу гүйцээв.

Энэ ажилд багш Дашдэлэг, Баямаа нарын удирдсан бригад, сурагч Хуягт, Батсүх, Дүгэржав, Жаргалсайхан нар онц идэвхтэй ажиллав.

**Манай идэвхтэн сурвалжлагч**

### ЛҮНГИЙН БҮСЭЭС

Саяхан Заамар сум-нэгдлийн төвд Лүн бүсийн сумдын уралдааны комиссууд 1969 оны III улирлынхаа социалист уралдааныг дүгнэв.

1969 оны төлөвлөгөөт 46 үзүүлэлтээр уралдаанаа дүгнэсэн. Лүн бүсээс Заамар сум-нэгдэл 86 баалаар тэргүүн байр, Угтаал, Баянцогт сум, САА 98—103 баал авч хоёр, гуравдугаар байр, Лүн сум 123 баалаар сүүлийн байранд орлоо.

Лүн бүсийн сумдын уралдааны төлөвлөгөөт үзүүлэлтийн явц дийлэнх нь 100-аас дээш хувийн биелэлттэй байгаа нь энэ сум, САА—нуудын төлөвлөгөөт ажил нилээд амжилттай явааг харуулж байна.

Гэсэн ч энэ бүсийн сумдын хадлан авалт, тариа хураалтын ажил тун хангалтгүй гүйцэтгэлтэй байгаад дээрх сумдын удирдах нөхөд тодорхой дүгнэлт хийвэл зохино.

**Манай сурвалжлагч**

## Найрамдлын сараар

Монгол—Зөвлөлтийн найрамдлын сарыг тохиолдуулан В. И. Лениний мэндэлсний 100 жилийн ойг угтаж өөрийн орны болон ЗХУ-ын сонин сэтгүүл захиаллага амжилттай явагдаж байна.

Үүнд: Зөвлөлт Холбоот улсын 46 төрлийн 6281 төгрөгний хэвлэл захиаллаа. Мөн «Зөвлөлт Холбоот улс» сэтгүүл, «Анхдугаар таван жил» сонинг өрх бүр захиалав гэж Борнуур сум САА—гаас цахилгаанаар мэдээлэв.

